

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянлиг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **БНА-2026/133/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/99

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянлиг сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр Баянлиг сумын ИТХ-ын хуралдааны 2025.10.14-ны өдрийн 7/1 дугаар тогтоолоор орон нутгаас олгох санхүүжилтийг 1,087,235.2 мянган төгрөгөөр баталж, тайлант онд баталсан санхүүжилтийн 96.5 хувь буюу 1,048,975.7 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авч, үүнээс үйл ажиллагааны зардалд 1,035,596.7 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 13,379.0 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050312  
/2026 он/1. бичиг хэрэглээ/2. а4-  
албан тоот.docx

Баянлиг сумын ЗДТГ-ын 2025 оны төсөвт Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд 13,000.0 мянган төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 7,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Баянхонгор аймгийн Баянлиг сумын ЗДТГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагаас 91 хувьтай үнэлсэн бөгөөд эрх бүхий байгууллагаас үнэлгээ ирээгүй байна.

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ

Хоёр: Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>АВЛАГА</b>	12,628,305.00	12,628,305.00
Бусад авлага	12,628,305.00	12,628,305.00
Хувь хүмүүсээс авах авлага	12,628,305.00	12,628,305.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>237,308,022.50</b>	<b>192,122,450.50</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>19,166,390.00</b>	<b>62,693,818.00</b>
Тусгай зориулалттай материал	19,166,390.00	62,693,818.00
<b>Хангамжийн материал</b>	<b>214,121,990.50</b>	<b>125,408,990.50</b>
Бичиг хэргийн материал	4,193,804.00	6,005,804.00
Аж ахуйн материал	69,915,120.00	73,615,120.00
Бусад хангамжийн материал	140,013,066.50	45,788,066.50
Мал, амьтад	4,019,642.00	4,019,642.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,178,178,617.30</b>	<b>4,315,631,103.84</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
Биет хөрөнгө	4,094,535,261.76	4,238,857,752.59
Барилга, байгууламж	5,542,498,874.60	5,298,048,874.60
Хуримтлагдсан элэгдэл	(2,122,325,763.34)	(2,130,765,435.10)
Авто тээврийн хэрэгсэл	261,661,911.00	459,993,191.00
Хуримтлагдсан элэгдэл	(174,251,318.61)	(159,810,222.21)
Машин, тоног төхөөрөмж	443,826,320.50	385,840,529.50
Хуримтлагдсан элэгдэл	(303,793,637.51)	(175,280,013.29)
Тавилга, аж ахуйн эд хогшил	171,767,527.09	268,583,810.54
Хуримтлагдсан элэгдэл	(113,237,081.69)	(76,324,518.83)
Зам гүүрний барилга байгууламж	32,752,760.00	32,752,760.00
Хуримтлагдсан элэгдэл	(10,065,723.76)	(11,363,054.02)
Бусад үндсэн хөрөнгө	493,137,465.00	481,526,565.00
Хуримтлагдсан элэгдэл	(127,436,071.52)	(134,344,734.60)
Биет бус хөрөнгө	83,643,355.54	76,773,351.25
Программ хангамж	2,704,060.00	1,900,000.00
Хасагдуулга	(2,704,060.00)	(1,900,000.00)
Бусад биет бус хөрөнгө	103,482,750.00	103,482,750.00
Хасагдуулга	(19,839,394.46)	(26,709,398.75)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,178,178,617.30</b>	<b>4,315,631,103.84</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,428,114,944.80</b>	<b>4,520,381,859.34</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Өглөг</b>	-	14,862,934.81
Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	1,261,387.31
Бусад өглөг	-	13,601,547.50
Байгууллагад төлөх өглөг	-	12,987,047.50
Хувь хүмүүст төлөх өглөг	-	614,500.00
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>14,862,934.81</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>14,862,934.81</b>
Засгийн газрын хувь оролцоо	4,428,114,944.80	4,505,518,924.53
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	513,423,011.50	513,423,011.50
Өмч: -Төрийн өмч	513,423,011.50	513,423,011.50
Хуримтлагдсан үр дүн	3,846,331,235.60	3,924,144,207.08
Өмнөх үеийн үр дүн	3,846,331,235.60	3,846,740,227.35
Тайлант үеийн үр дүн	-	77,403,979.73
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,360,697.70	67,951,705.95
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,428,114,944.80</b>	<b>4,505,518,924.53</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,428,114,944.80</b>	<b>4,520,381,859.34</b>

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,582,712,212.50	1,656,731,824.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	626,965,956.00	594,560,398.00
Нийтлэг татварын бус орлого	625,265,956.00	594,560,398.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	625,265,956.00	594,560,398.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,268,400.00	11,424,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	490,081,756.00	480,138,670.00
үнэ төлбөргүй хүлээн авсан орлого / бараа материал/	130,915,800.00	102,997,728.00
Тусламжийн орлого	1,700,000.00	-
Хандив тусламж /дотоод/	1,700,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,746,256.50	1,062,171,426.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	43,304,056.50	13,195,726.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон	37,841,056.50	11,676,693.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,463,000.00	1,519,033.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	912,442,200.00	1,048,975,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага	912,442,200.00	1,048,975,700.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,399,708,517.15	1,579,327,844.27
УРСГАЛ ЗАРДАЛ	1,399,708,517.15	1,579,327,844.27
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,334,421,987.00	1,553,520,272.76
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	638,494,787.54	732,212,286.10
Цалин	420,440,218.54	438,836,521.47
Нэмэгдэл цалин	213,730,569.00	254,395,214.63
Унаа хоолны хөнгөлөлт	4,324,000.00	2,470,000.00
Урамшуулал	-	35,190,550.00
Гэрээтийн цалин	-	1,320,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,915,687.81	91,915,751.36
Тэтгэврийн даатгалын шимтгэл	52,743,482.26	62,768,168.25
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,376,072.70	7,347,280.89
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,221,627.95	3,730,027.50
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,156,539.84	3,586,879.86
Эрүүл мэндийн даатгалын хураамж	13,417,965.06	14,483,394.86
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,275,549.00	51,526,424.02
Гэрэл цахилгааны зардал	4,967,429.00	8,582,284.02
Түлш, халаалтын зардал	35,308,120.00	42,944,140.00
Хангамж, бараа материалын зардал	89,351,047.60	227,669,817.82
Бичиг хэргийн материал	9,233,800.00	5,269,800.00
Тээвэр, шатахууны зардал	44,447,615.00	32,922,738.00
Шуудан холбоо интернэтийн төлбөр	3,564,000.00	3,564,000.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	26,310,499.60	32,739,979.82
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,287,000.00	153,173,300.00
Бараа материал акталсны зардал	4,508,133.00	-
Нормативт зардал	-	1,860,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,860,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,440,000.00	10,585,700.00
Урсгал засвар	1,440,000.00	10,585,700.00
Томилолт, зочны зардал	7,697,950.50	4,588,000.00
Дотоод томилолтын зардал	7,697,950.50	4,588,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,733,105.00	2,987,220.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,360,574.00	417,500.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	289,575.00	436,250.00
Тээврийн хэрэгслийн татвар	389,956.00	586,806.00

Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	605,000.00	850,000.00
Газрын төлбөр	-	608,664.00
Бараа үйлчилгээний бусад зардал	473,513,859.55	430,175,073.46
Бараа үйлчилгээний бусад зардал	29,356,510.00	16,414,890.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	444,157,349.55	413,760,183.46
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,286,530.15	25,807,571.51
Бусад урсгал шилжүүлэг	55,145,387.00	10,909,500.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,128,295.00	1,980,000.00
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,517,092.00	8,929,500.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,500,000.00	-
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,141,143.15	14,898,071.51
Төвлөрүүлэх шилжүүлэг	6,081,234.15	13,379,038.51
Хөрөнгийн	4,059,909.00	1,519,033.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	183,003,695.35	77,403,979.73
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	8,036,000.00	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,036,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(8,036,000.00)	-
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	174,967,695.35	77,403,979.73

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	961,714,656.50	1,073,595,426.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,968,400.00	11,424,000.00
Нийтлэг татварын бус орлого	4,268,400.00	11,424,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,268,400.00	11,424,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,268,400.00	11,424,000.00
Тусламжийн орлого	1,700,000.00	-
Хандив тусламж /дотоод/	1,700,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,746,256.50	1,062,171,426.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	43,304,056.50	13,195,726.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон	37,841,056.50	11,676,693.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,463,000.00	1,519,033.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	912,442,200.00	1,048,975,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	912,442,200.00	1,048,975,700.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	948,655,097.50	1,002,521,426.00
УРСГАЛ ЗАРДАЛ	948,655,097.50	1,002,521,426.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,063,475.85	976,713,854.49
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	638,494,787.54	731,087,843.38
Үндсэн цалин	372,324,033.00	408,933,315.01
Нэмэгдэл	240,635,284.54	275,102,688.68
Унаа хоолны хөнгөлөлт	4,030,000.00	5,276,416.00
Үр дүнгийн урамшуулал	21,505,470.00	36,231,443.69
Гэрээт ажлын хөлс	-	5,543,980.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,669,979.71	91,357,188.59
Тэтгэврийн даатгалын шимтгэл	54,153,669.92	62,060,409.35
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,030,562.98	7,324,194.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,015,280.50	3,662,198.12

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,915,867.10	3,662,198.12
Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,554,599.21	14,648,189.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	40,275,549.00	51,086,424.02
Гэрэл цахилгааны зардал	4,967,429.00	8,073,795.23
Түлш, халаалтын зардал	35,308,120.00	43,012,628.79
Хангамж, бараа материалын зардал	66,666,865.60	64,269,708.00
Бичиг хэрэг	5,613,800.00	3,972,000.00
Тээвэр, шатахуун	20,000,000.00	20,251,670.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.00	2,673,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,649,065.60	36,573,038.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840,000.00	800,000.00
Нормативт зардал	-	400,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	400,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,408,000.00	13,172,200.00
Багаж техник хэрэгсэл	-	203,500.00
Урсгал засвар	1,408,000.00	12,968,700.00
Томилолт, зочны зардал	6,040,400.00	4,588,000.00
Дотоод албан томилолт	6,040,400.00	4,588,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,260,920.00	2,809,720.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	10,475,389.00	225,500.00
Даатгалын үйлчилгээ	745,575.00	500,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	389,956.00	525,556.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	88,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	995,000.00
Газрын төлбөр	-	475,664.00
Бараа үйлчилгээний бусад зардал	44,246,974.00	17,942,770.50
Бараа үйлчилгээний бусад зардал	44,246,974.00	17,942,770.50
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,591,621.65	25,807,571.51
Бусад урсгал шилжүүлэг	54,510,387.50	10,909,500.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,128,295.00	1,980,000.00
Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,882,092.50	8,929,500.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,500,000.00	-
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,141,143.15	14,898,071.51
Төвлөрүүлэх шилжүүлэг	6,081,234.15	13,379,038.51
Төвлөрүүлэх шилжүүлэг / нэмэлт данс/	4,059,909.00	1,519,033.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,059,559.00	71,074,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,999,650.00	71,074,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,999,650.00	71,074,000.00
Дотоод эх үүсвэрээр	8,999,650.00	71,074,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,999,650.00	71,074,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,999,650.00)	(71,074,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
<b>2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	513,423,011.50	68,360,697.70	3,846,331,235.60	4,428,114,944.80
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	513,423,011.50	68,360,697.70	3,846,331,235.60	4,428,114,944.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			408,991.75	408,991.75
<b>Залруулсан үлдэгдэл</b>	513,423,011.50	68,360,697.70	3,846,740,227.35	4,428,523,936.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-408,991.75		-408,991.75
Тайлант үеийн үр дүн			77,403,979.73	77,403,979.73
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	513,423,011.50	67,951,705.95	3,924,144,207.08	4,505,518,924.53

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,075,811,200.00	1,035,596,661.49	40,214,538.51	96.26
Орон нутгийн төсвөөс	1,075,811,200.00	1,035,596,661.49	40,214,538.51	96.26
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,424,000.00	11,424,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,424,000.00	11,424,000.00	-	100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,087,235,200.00	1,047,020,661.49	40,214,538.51	96.30
Ажиллагчидтай холбогдсон зардал	823,997,500.00	822,445,031.97	1,552,468.03	99.81
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,442,500.00	731,087,843.38	1,354,656.62	99.82
Үндсэн цалин	408,933,100.00	408,933,315.01	(215.01)	100.00
Нэмэгдэл	275,102,700.00	275,102,688.68	11.32	100.00
Унаа, болон бусад нөхөн олговор	5,276,500.00	5,276,416.00	84.00	100.00
Урамшуулал	37,586,200.00	36,231,443.69	1,354,756.31	96.40
Гэрээт ажлын хөлс	5,544,000.00	5,543,980.00	20.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,555,000.00	91,357,188.59	197,811.41	99.78
Тэтгэврийн даатгал	62,257,300.00	62,060,409.35	196,890.65	99.68
Тэтгэмжийн даатгал	7,324,500.00	7,324,194.00	306.00	100.00
ҮОМШӨ ний даатгал	3,662,200.00	3,662,198.12	1.88	100.00
Ажилгүйдлийн даатгал	3,662,200.00	3,662,198.12	1.88	100.00
Эрүүл мэндийн даатгал	14,648,800.00	14,648,189.00	611.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,004,100.00	51,086,424.02	3,917,675.98	92.88
Гэрэл цахилгаан	12,000,000.00	8,073,795.23	3,926,204.77	67.28
Түлш, халаалт	43,004,100.00	43,012,628.79	(8,528.79)	100.02
Хангамж, бараа материалын зардал	82,990,000.00	64,189,085.50	18,800,914.50	77.35
Бичиг хэрэг	6,880,000.00	3,972,000.00	2,908,000.00	57.73
Тээвэр (шатахуун)	34,690,000.00	19,599,047.50	15,090,952.50	56.50

Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.00	2,673,000.00	891,000.00	75.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,856,000.00	37,145,038.00	(289,038.00)	100.78
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	800,000.00	200,000.00	80.00
Нормативт зардал	636,100.00	400,000.00	236,100.00	62.88
Нормын хувцас зөөлөн эдлэл	636,100.00	400,000.00	236,100.00	62.88
Эд хогшил худалдан авах	30,025,100.00	28,674,200.00	1,350,900.00	95.50
Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,993,500.00	6,500.00	99.94
Тавилга	7,000,000.00	6,284,000.00	716,000.00	89.77
Урсгал засвар	13,025,100.00	12,396,700.00	628,400.00	95.18
Томилолт, зочны зардал	5,000,000.00	4,588,000.00	412,000.00	91.76
Дотоод албан томилолт	5,000,000.00	4,588,000.00	412,000.00	91.76
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,872,400.00	2,809,720.00	3,062,680.00	47.85
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	225,500.00	774,500.00	22.55
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	800,000.00	-	800,000.00	-
Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,522,500.00	525,556.00	996,944.00	34.52
Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	88,000.00	212,000.00	29.33
Мэдээллийн технологийн зардал	1,149,900.00	995,000.00	154,900.00	86.53
Газрын төлбөр	600,000.00	475,664.00	124,336.00	79.28
Бараа үйлчилгээний бусад зардал	80,230,000.00	70,848,200.00	9,381,800.00	88.31
Бараа үйлчилгээний бусад зардал	80,230,000.00	70,848,200.00	9,381,800.00	88.31
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,480,000.00	1,980,000.00	1,500,000.00	56.90
Бусад урсгал шилжүүлэг	3,480,000.00	1,980,000.00	1,500,000.00	56.90
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,980,000.00	1,980,000.00	-	100.00
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,087,235,200.00</b>	<b>1,047,020,661.49</b>	<b>40,214,538.51</b>	<b>96.30</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,087,235,200.00</b>	<b>1,047,020,661.49</b>	<b>40,214,538.51</b>	<b>96.30</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	-	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,195,726.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,195,726.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,747,193.00</b>
Хангамж, бараа материалын зардал	652,622.50
Тээвэр, шатахуун	652,622.50
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2094570.50</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	2,094,570.50
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8929500.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,929,500.00</b>

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,929,500.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,519,033.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13195726.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,195,726.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,676,693.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,519,033.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

**Гурав.** Аудитаар нийт 50,327.2 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 50,327.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, газрын зөрчлийг арилгах үнийн дүнгүй 1 албан шаардлагыг хүргүүлэв.

Нийт илрүүлсэн 50,327.2 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус алдаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **3.1. Албан шаардлага**

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 6401001937, 64010001846, 6401001844, 6401001812 нэгж талбарын дугаартай газруудыг үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана” гэсэн заалт болон УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэргэжлийн байгууллагаар газрын үнэлгээг хийлгэж, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тооцоо нийлж, нягтлан бодох бүртгэлд бүртгэж зөрчлийг арилгах

### **3.2. Зөвлөмж**

1. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 2023 онд бүртгэсэн, 36,067.5 мянган төгрөгийн үнэ бүхий 0.4 квт өргөтгөлийн ашиглах жилийг 0 жилээр оруулснаас хөрөнгөд хуримтлагдсан элэгдэл бодоогүй зөрчлийг илрүүлж, ашиглах жилийг оруулахыг зөвлөсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Үндсэн хөрөнгийн бүртгэлд УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, УСНББОУС 21 “Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт”, УСНББОУС 26 “Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт”, УСНББОУС 5 “Зээлийн өртөг” -ийг мөрдөнө”, Сангийн сайдын 2024 оны А/03 дугаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.24.Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглаж эхэлсэн хугацаанд үндэслэн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар цаашид ашиглах жилийг хэлэлцүүлэн тогтоож, хуримтлагдсан элэгдэл тооцож, элэгдлийн зардлаар бүртгэж тайлагнах

2. Тайлант онд 7,975.7 мянган төгрөгөөр урсгал завсар хийх, 6,284.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна” гэсэн заалт болон Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь “Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” заалт, УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг тухай бүрд гаргаж, санхүүгийн баримтад хавсаргаж, биелэлтийг тооцож байх

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 6401001937, 64010001846, 6401001844, 6401001812 нэгж талбарын дугаартай газруудыг үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	0			1	0						
Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 2023 онд орлого авсан 0.4 квт өргөтгөлийн ашиглах жилийг 0 жилээр оруулснаас хөрөнгөд хуримтлагдсан элэгдэл бодоогүй зөрчлийг илрүүлж, ашиглах жилийг оруулахыг зөвлөсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	36,067.5					1	36,067.5				
Тайлант онд 7,975.7 мянган төгрөгөөр урсгал завсар хийх, 6,284.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй байна.	1	14,259.7					1	14,259.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>50,327.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>50,327.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

---oOo---